



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/963

Мандалговь


Газар эзэмшүүлэх хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйл 21.3.2, 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21 дүгээр зүйлийн ХХ.1.43 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21 дүгээр зүйлийн ХХ.1.43 дахь хэсэгт тусгагдсан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх " ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтанд заасан 2 байгууллагад 2905 м.кв (0,29га) газрыг эзэмшүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хавсралтанд заасан аймгийн Засаг даргын захирамжийн холбогдох хэсгийг мөн газар эзэмших гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Хавсралтанд заасан иргэд болон аж ахуй нэгжтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



482010463